

**БНМАУ-ЫН ГАДААД БОДЛОГЫГ СУДЛАХ АСУУДАЛ****С. Ишдорж**

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Аугаа их Октябрийн нөлөөгөөр 1921 онд ялсан Монгол Ардын хувьсгалын гол үр дүн-монголын ардын төр нь улс орны дотоод дахь нийгэм-эдийн засгийн байгууллын ангич мөн чанар, шинэ нийгэм цогцлон байгуулах монголын ард түмний чин эрмэлзлэлээс урган гарсан гадаад бодлогыг явуулсаар байна. МАХН, БНМАУ-ын засгийн газар өөрийн гадаад бодлогын чиг шугамыг тодорхойлохдоо орчин үеийн шинж, социалист хамтын нөхөрлөлийн улсууд болон дэлхийн хувьсгалт үйл явцын интернационалч зорилтыг тусган оруулдаг юм.

БНМАУ-ын гадаад бодлогын үндсэн чиглэлүүд гэвэл, ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад улстай тогтоосон найрамдал, хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэн бэхжүүлэх, дэлхийн социализмын орнуудын эв нэгдлийг байнга бататах, ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжих, нийгмийн янз бүрийн байгуулалтай улсуудын энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг тууштай хэрэгжүүлэх, империалист харгис дайнч түрэмгий хүчинд няцаалт өгөх, бат бэх энх тайван, нийгмийн дэвшлийн төлөө улс түмний тэмцэлд империализмыг эсэргүүцсэн хувьсгалт хүчний эв нэгдлийг хангахад тус дөхөм үзүүлэх явдал юм.

БНМАУ-аас дэлхийн социализмын орнуудтай найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлж байгаагаас зөвхөн хоёр гол зүйлийг энд тэмдэглэе. Үүнд:

Нэгд. БНМАУ, ЗХУ-ын хөгжлийн түүхэн нөхцөл нь эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамтын хүчээр өмгөөлөн хамгаалах, шинэ нийгэм байгуулах зорилтыг шийдвэрлэх, бусад улс түмний өмнө хүлээсэн интернационалч үүргээ биелүүлэхийн тулд тус хоёр орныг харилцан гүн зузаан найрамдал, бат бэх холбоо тогтоон ажиллахад хүргэжээ.

Чин сэтгэлийн үүднээс харилцан туслах шинжээр тодорч, цаг үеийн хатуу ширүүн шалгалт сорилтыг амжилттай даван туулсан монгол-зөвлөлтийн найрамдал нь БНМАУ-ын эрх чөлөө, тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтийн найдвартай баталгаа ямагт болж байсан. одоо ч болсоор байна. ЗХУ-тай тогтоосон эв нэгдэл, найрамдлыг ямар нэг хэлбэрээр сулруулж, үндэсний явцуу байдлын замд орох аливаа алхам нь БНМАУ-ыг империалист, жанжлах хүчнээс хамаарагдах байдалд оруулж, эцсийн эцэст төрийн бүрэн эрхт байдлаа алдаж болох аюултай гэдгийг манай орны хөдөлмөрчин бүр гүнээ ухамсарлаж байдаг юм.

БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын харилцаа нь социалист улсуудын хамтын нөхөрлөл бүрэлдэн төлөвшихөд чухал үүрэг гүйцэтгэж, жинхэнэ тэгш эрх, ах дүүгийн хамтын ажиллагаа, социалист интернационализмын зарчимд тулгуурласан шинэ маягийн олон улсын харилцааны загвар болжээ. Социализмын ах дүү орнуудын хоорондын улс төр, батлан хамгаалах, эдийн засаг, шинжлэх ухаан техник, соёлын болон бусад харилцаа-

ны бүхий л системийг социалист эв санааны нэгдлийн үзэл тодорхойлж байна.

БНМАУ-аас дэлхийн социализмын бусад оронтой тогтоосон найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа жилээс жилд хөгжин бэхжсээр байна.

Хоёрт. БНМАУ 1962 онд Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн гишүүнээр элссэн нь түүнээс социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай харилцахад шинэ үе болжээ. ЭЗХТЗ-ийн хүрээнд социалист эдийн засгийн интеграцийн Цогцолбор Программыг хэрэгжүүлэх хоёр болон олон талын хамтын ажиллагааг явуулж, ЗХУ, социалист бусад оронтой БНМАУ бүх талаар ойртон нягтарч байгаа нь улс орны ажиллах хүч, санхүү-материалын хязгаарлагдмал нөөцтэй холбоо бүхий бэрхшээлийг амжилттай гэтлэн давж, өөрийнхөө дотоод эх үүсвэрийг дээд зэргээр дайчлахын зэрэгцээ олон улсын социалист хөдөлмөрийн хуваарийн давуу байдалд тулгуурлах боломжийг монголын ард түмэнд олгож, БНМАУ-ын хөгжлийг хурдасгахад тус дөхөм үзүүлж байна.

Ах дүү социалист орнууд, юуны өмнө ЗХУ-ын үзүүлж буй техник-эдийн засгийн болон бусад тусламж нь манай оронд социализм байгуулахын шийдвэрлэх хүчин зүйлийн нэг болж байна.

Монголын ардын төрийн гадаад бодлогын өөр нэг чухал чиглэл бол улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжиж байдаг явдал мөн.

БНМАУ социалист чиг баримжааны Афганистан, Кампучи, Ангол, Эфиопи болон бусад оронтой найрамдал, эв санааны нэгдлийн харилцааг хөгжүүлж байна.

БНМАУ социализмын ах дүү орнууд болон хувьсгалт бусад хүчний хамт биеэ даасан үндэсний улсуудын ард түмнээс өөрсдийн орны улс төрийн тусгаар тогтнол, эдийн засгийн биеэ даасан байдлыг бэхжүүлэхийн төлөө, нийгмийн дэвшлийн төлөө, шинэ колоничлолын өнгөлзлөгийг зогсоох, олон улсын эдийн засгийн харилцааны шударга систем тогтоохын төлөө явуулж буй тэмцлийг идэвхтэй дэмжиж байна.

БНМАУ-аас Ази, Африкийн биеэ даасан үндэсний улсууд, тухайлбал Азийн том улс-Энэтхэгтэй түүнчлэн Латин Америкийн нилээд оронтой найрамдалт харилцааг амжилттай хөгжүүлж байгаа нь улс түмний энх тайван, аюулгүй байдлын үйлсэд тус дөхөм болж байна.

БНМАУ империализмын дарамт шахалт, харгис дайнч, арьсны үзэлт дэглэм-сионизмын түрэмгийлэл, аллага хядлагад нэрвэгдэж буй улс түмний тэмцэлд бололцоотой бүх дэмжлэгийг үзүүлж байна. Монголын ард түмэн Палестин, Ливаны эх орончид, Никарагуа, Сальвадор болон бусад орны ард түмний шударга тэмцэлтэй эв санааны бүрэн нэгдэлтэй байдаг юм.

Нийгмийн янз бүрийн байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших ленинч зарчмыг хэрэгжүүлэх нь монголын ардын төрийн гадаад бодлогын тулгуур зарчмуудын нэг юм.

БНМАУ нийгэм-эдийн засгийн өөр байгуулал бүхий улсуудтай төрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харцлцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох үндсэн дээр хэвийн харилцааг тогтоон хөгжүүлж, өөрийн үндэсний ашиг сонирхол, эрхийг тууштай хамгаалж ирэв. 1961 оны 10-р сард БНМАУ Нэгдсэн Үндэстний Байгууллагад элс-сэнээр манай улсыг олон жилийн турш гадуурхсан бодлого эцэс болж, БНМАУ-ыг нийгмийн өөр байгуулал бүхий улсууд өргөнөөр хүлээн зөвшөөрөх үе эхэлжээ. БНМАУ-ыг Их Британи, Франц, ХБНГУ, Итали зэрэг капиталист гол орнууд хүлээн зөвшөөрсөн билээ.

БНМАУ, нөхөр Ю.Цэдэнбалын хэлснээр, «олон улсын харилнааны системд зохих байр сууриа эзэлж, дэлхийн улс түмний дунд нэр хүндтэй боллоо»<sup>1</sup>

Одоо БНМАУ дэлхийн 93 оронтой дипломат харилцаа барьж, 30 гаруй улстай худалдаа-эдийн засгийн харилцааг хөгжүүлэн, 40 гаруй оронтой соёлын хэлхээ холбоотой ажиллаж байна. Манай орон олон улсын 70 шахам байгууллагын гишүүнээр ажиллаж, тэдгээрийн ажилд идэвхтэй оролцон, тэдгээр байгууллага, ялангуяа олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах чухал байгууллага -НҮБ-ын үйл ажиллагааг онцгой ач холбогдолтой гэж үздэг юм. Манай гадаад бодлогын энэ үйл ажиллагааг Л.И.Брежнев өндөр үнэлж, 1974 оны 11-р сард Улаанбаатар хотноо болсон баярын хурал дээр хэлэхдээ, БНМАУ-ын дуу хоолой «одоо олон улсын тавцан дээр жинтэй бөгөөд нэр хүндтэй сонсогдож байна. Учир нь энэ бол энх тайван, шударга ёсны дуу хоолой мөн»<sup>2</sup> гэсэн билээ.

БНМАУ, ЗХУ болон энхийг эрхэмлэгч бусад улстай хамтран дэлхийн халуун цөмийн сүйрлийн аюулыг зайлуулах, үй олноор бүрэлгэгч цөмийн болон бусад төрлийн зэвсгийг хорогдуулан хориглох, зэвсгийн хойноос хөөцөлдөхийг зогсоох, зэвсгийг хураах, олон улсын тулгамдсан асуудлыг улс төрийн хэлэлцээний аргаар шийдвэрлэх, дэлхийн янз бүрийн район дахь мөргөлдөөнийг арилгахын төлөө идэвхтэй тэмцэж байна. Энэ оны 8-р сард Крымд болсон БНМАУ, ЗХУ-ын нам, төрийн тэргүүн нарын уулзалтын тухай албан мэдээнд «Аль аль нь чин сэтгэлээсээ сонирхож, урьдаас сэжиглэх, үл итгэх явдал гаргахгүй байвал хэлэлцээ хийх аргаар шийдвэрлэж болохгүй тийм асуудал байхгүй»<sup>3</sup> гэж цохон тэмдэглэжээ.

ЗХУКН-ын XXVI их хурлаас дэвшүүлсэн 80-аад оны энх тайвны Программ, дэлхийн халуун цөмийн түймрийн аюулыг зайлуулах талаар ЗХУ-аас НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXVII чуулганд тавьсан санал нь улс түмний энх тайван, аюулгүй байдлыг сахин бататгах үйлсэд онцгой ач холбогдолтой юм. Ялангуяа зэвсэг хураах асуудлаар энэ онд хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулган дээр ЗХУ цөмийн зэвсгийг эхэлж хэрэглэхгүй тухай үүргийг өөртөө дангаараа авсан нь туйлын энэрэнгүй зүйл мөнөөр барахгүй дэлхийн бүх улс түмний амин эрх ашигт бүрэн дүүрэн нийцэж байгаа чухал алхам мөн.

БНМАУ Азийн энхийг эрхэмлэгч социалист орны хувьд бүх хүн төрөлхтний тэн хагасаас илүү нь оршин амьдардаг энэ тивд энх тайвныг сахин бататгах талаар их анхаарал тавьж байдаг билээ. Өнгөрсөн онд хуралдсан МАХН-ын XVIII их хурлаас «Ази, Номхон далайн улсуудын харилцаанд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай Конвенц боловсруулж гарын үсэг зурах»<sup>4</sup> талаар дэвшүүлсэн санал дээрх ариун зорилгод чиглэж байгаа юм. Манай энэ санал дэлхийн энхийг эрхэмлэгч улсууд, олон улсын өргөн олон нийтийн дэмжлэгийг улам бүр олж байна.

Дэлхийн улс төрийн байдал хурцадмал байгаа өнөөгийн нөхцөлд олон улсын энх тайван бүх нийтийн аюулгүй байдлын төлөө улс түмний тэмцлийг хэзээ хэзээнээс илүү улам хүчтэй өрнүүлэх зорилт тавигдаж байна.

Монголын ардын төрийн гадаад бодлогыг хоёр үндсэн шат болгож хувааж болно. Үүнд:

**Нэгдэх шат** нь 1921 оноос 1945 оны үеийг хамарч байна. Энэ шатанд Ардын эрхт Монгол улс ЗХУ-тай хамт капиталист хүрээлэлд оршин,

1. Ю. Цэдэнбал. «Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал». УБ., 1976, 687- р тал.

2. «Правда», 1974 оны 11-р сарын 27.

3. «Үнэн», 1982 оны 8-р сарын 21.

4. «Монгол Ардын Хувьсгалт Намын XVIII их хурал. УБ.. 1981. 88-р тал.

төрийн тусгаар тогтнолоо бэхжүүлэх, эдийн засгийн биеэ даасан байдлыг хангах, капиталист биш хөгжлийн замаар замнан социализмд шилжих энх тайван нөхцлийг бүрэлдүүлэх, дэлхийн II дайны жилүүдэд фашист түрэмгийлэгчдийн эсрэг улс түмний чөлөөлөх тэмцлийг дэмжих, юуны өмнө германы фашизмтай хамгийн хатуу ширүүн тулалдаан хийж байсан зөвлөлтийн ард түмэнд туслах, уг дайны төгсгөлд японы милитаризмыг бутцохиход өөрийн цэргээр шууд оролцох, Алс Дорно дахинд энх тайвныг тогтооход чиглэсэн гадаад бодлого явуулж байв.

Энэ шатыг дотор нь 2 үе болгон үзэж болох мэт санагдана.

1-р үе нь Монголын Ардын хувьсгал ялсан цагаас эхэлж 1930-аад оны эхэн хүртэл үргэлжилжээ. Энэ үед Монголын ардын төр өөрийн гадаад бодлогын зарчмуудыг тодорхойлоод, ЗХУ-д түшиглэн төрийн байлдан олсон тусгаар тогтнолоо бататгах, эдийн засгийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн гадаад бодлого явуулж байв. Ардын хувьсгал ялсны дараа монголын ард түмэн МАХН-ын удирдлагын дор улс орноо капиталист биш хөгжлийн замаар хөгжүүлэх чиг шугамыг сонгон авч түүнийг олон улсын коммунист хөдөлгөөн, Коминтерн, юуны өмнө ЗХУКН-ын дэмжлэгтэйгээр баруун, «зүүний» хэлбэрлээс өмгөөлөн хамгаалж тууштай хэрэгжүүлэн, 1924 онд БНМАУ-ыг тунхаглаж, 1929 он гэхэд гадаадын капиталыг улс орноосоо шахан зайлуулж, 1930 онд улс орны гадаад худалдаанд ардын төрийн монополь эрхийг тогтоов. Үүний үр дүнд тус орны эдийн засгийн бие даасан байдал хангагдаж, өөрөөр хэлбэл Монголын эдийн засаг дэлхийн капиталист системийн аж ахуйгаас үл хамаарагдах болжээ.

2-р үе нь 1930-аад оны эхнээс 1945 оныг хамарч байна. Энэ үед БНМАУ капиталист биш хөгжлийн замд эргэлтгүй орж, социализмын үндсийг тавьж эхлэн, японы дайнчид Манжуурийг эзлэн авсаны улмаас Япон манай оронд шууд заналхийлэх болж, Алс Дорно дахинд дайны голомт бий болсонтой холбогдуулан ЗХУ-д түшиглэн, батлан хамгаалах хүчээ бүх талаар бэхжүүлэх явдлыг нэн тэргүүний зорилт болгосон юм. Дэлхийн 2-р дайн дуусах хүртэлх энэ үеийн БНМАУ-ын гадаад бодлого нь японы түрэмгийллээс ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламжтайгаар улс орны төрийн тусгаар тогтнол, монголын ард түмний хувьсгалт ололтыг өмгөөлөн хамгаалах. Эх орны аугаа их дайны жилүүдэд ах дүү зөвлөлтийн ард түмний баатарлаг тэмцлийг дэмжих, Алс Дорно дахинд дайны галыг унтрааж бат бэх энх тайван байдлыг бий болгоход чиглэж байлаа.

БНМАУ хувь нэмрээ оруулсан ялалтын 1945 он нь манай улсын гадаад байдлыг ихэд бэхжүүлж, түүний төрийн тусгаар тогтнолын батжилд эргэлтийн он болов.

1945 оны 2-р сард Ялтад болсон гитлерийн эсрэг эвслийн 3 гол гүрний тэргүүн нарын бага хурал дээр АНУ, Их Британиар, мөн оны 8-р сард Москвад явагдсан зөвлөлт-хятадын хэлэлцээний үеэр гоминьданы Хятадаар БНМАУ-ын төрийн тусгаар тогтнолыг ЗХУ зөвшөөрүүлсэн билээ. Гоминьданы засгийн газрын шаардлагаар 1945 оны 10-р сарын 20-нд БНМАУ-д төрийн тусгаар тогтнолын төлөө монголын бүх ард түмний санал хураалт явагдсан юм. Уг санал хураалт улс орныхоо төрийн тусгаар тогтнолын төлөө монголын бүх ард түмэн нэгэн зориг, нэгэн эрмэлзэлтэй байгааг баттай нотлон харуулсаг юм.

Монголын ардын төрийн гадаад бодлогын хоёрдох шат нь 1945 оноос эхэлж одоо хүртэл үргэлжилж байна. Энэ шатанд БНМАУ дэлхийн тавцанд байдлаа ихэд бэхжүүлэн, социализмын үндсийг тавьж дуусгах, социализм байгуулахын энх тайван нөхцлийг хангах, олон улсын өргөн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх бодлогыг явуулж ирсэн, явуулсаар ч байна.

Энэ шатыг дотор нь 3 үе болгон хувааж болно.

1-р үе нь 1945 оноос 1960-аад оны эхэн хүртлэх үеийг хамаарч байна. Энэ үед БНМАУ нь ЗХУ болон дэлхийн, социализмын бусад оронтой найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх, үндэсний тусгаар тогтносон нилээд улстай найрамдалт харилцааг тогтоон хөгжүүлэхэд чиглэсэн гадаад бодлого явуулж, НҮБ-д хууль ёсны эрхээ эдлэхийн төлөө, империалист зарим гүрний эрх баригчид, чанкайшигийнхний хавчин гадуурхах бодлогын эсрэг тэмцэж, энхийг эрхэмлэгч бүх хүчинтэй хамтран, империалистуудын «хүйтэн дайны», «хүчээр түрээ барих», «коммунизмыг дайны ирмэг дээр байлгах» бодлогын эсрэг, улс түмний энх тайван аюулгүй байдлын төлөө идэвхтэй тэмцэж байв.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд ЗХУ-ын баримталсан жинхэнэ интернационалч тууштай байр суурийн ач, түүнчлэн ах дүү социалист бусад орон болон энхийг эрхэмлэгч улс түмний дэмжлэгтэйгээр БНМАУ НҮБ-д хууль ёсны эрхээ эдэлсэн юм.

Мөн БНМАУ олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлж байлаа. 2-р үе нь 1960-аад оны эхнээс 1970-аад оны дунд хүртэлх үеийг хамарч байна. Энэ үед БНМАУ ЭЗХТЗ-ийн гишүүн болж, түүний хүрээнд социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай хэрэгжүүлж байсан хоёр талын хамтын ажиллагаагаа олон талын хамтын ажиллагаа болгон өргөжүүлэв. БНМАУ НҮБ-ын гишүүн болсноос хойш манай улсыг нийгмийн өөр байгуулалттай орнууд зөвшөөрөн хүлээх үе эхлэв. Мөн манай улсаас олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах явдал өргөжив. Энэ үед МАХН, БНМАУ-ын засгийн газрын гадаад бодлогын үйл ажиллагаанд хятад дахь Мао Зэдуны удирдлагаас манай орны хувьд илт явуулж байсан өнгөлзөх бодлоготой тэмцэх асуудал бий болов.

БНМАУ социализмын ах дүү орнууд, энхийг эрхэмлэгч бусад, улс орон, хүчинтэй хамтран энх тайвны үйлсийг тууштай хамгаалж, олон улсын хурцадмал байдлыг намжаах үйл явцыг бий болгохын төлөө тэмцэж байлаа.

3-р үе нь 1970-аад оны дундаас эхэлж өнөө хүртэл үргэлжилж байна. Энэ үеийн онцлог шинж бол МАХН, БНМАУ-ын засгийн газар өөрийн оронд социализмын материал-техникийн баазыг түргэн байгуулж дуусгах, социалист эдийн засгийн интеграцын Цогцолбор Программыг амжилттай хэрэгжүүлэх зорилтоос үндэслэн, социалист хамтын нөхөрлөлийн орнууд, юуны түрүүн ЗХУ-тай бүх талаар ойртон нягтрахад чиглэсэн гадаад бодлого явуулж байгаа явдал юм. Энэ тухай МАХН-ын XVIII их хурлын (1976 он) материал, тухайлбал Намын Төв Хорооны тайлан илтгэлд тодорхой заасан билээ.

Энэ үед БНМАУ үндэстний залуу улсууд, түүнчлэн нийгмийн өөр байгуулал бүхий орнуудтай харилцаагаа улам өргөжүүлж ирэв. Мөн олон улсын байгууллагуудтай манай улсын хамтран ажиллах явдал бас өсөн нэмэгдлээ.

Одоо БНМАУ бүх хань нөхөдтэйгээ хамтран, дэлхийн халуун цөмийн дайны аюулыг зайлуулах, зэвсэглэлээр хөөцөлдөхийг хязгаарлан зогсоох, зэвсэг хураах, Ази болон дэлхий дахины улс түмний энх тайван, аюулгүй байдлыг сахин бататгахын төлөө идэвхтэй тэмцэж байна. «Манай гадаад бодлогын хувиршгүй зорилго бол бат бэх энх тайвныг хангаж, тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн төлөө улс түмний эрхийг хамгаалах явдал мөн»<sup>5</sup> гэж ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бич-

гийн дарга нөхөр Ю.В.Андроповоос ЗХУКН-ын Төв Хорооны 1982 оны 11-р сарын бүгд хурал дээр хэлсэн зүйлийг монголын олон нийт бүрэн дүүрэн сайшаан дэмжиж байна.

БНМАУ-ын гадаад бодлогын дээрхи үндсэн 2 шат, тэдгээрийн үеүүд нь тус бүрдээ дотроо бас онцлог мөчүүдтэй байгаа мэт санагдана. Энэ талаар зөвхөн жишээ болгон ганц мөчийг хэлэхэд, 2-р шатны 1945 оноос 1960-аад оны эхэн хүртэлх 1-р үеийн дотор 1950 он нь БНМАУ-аас ардын ардчилсан олонхи оронтой дипломат харилцаа тогтоосон онцлог он байлаа. Энэ мэт онцлог мөчүүд бусад бүх шат, үеүүдэд байж болох учир энэ талаар цаашид судалгааг улам гүнзгийрүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

БНМАУ-ын гадаад бодлогыг судлах асуудал манай түүхийн шинжлэх ухаанд болон гадаад орнуудын монгол судлалд ямар нэгэн хэмжээгээр тусгагдаж ирлээ. Тухайлбал зөвлөлтийн түүхчид монгол судлаачид, манай түүхчдийн хамтран бэлтгэсэн БНМАУ-ын түүхийн нэг боть, манай эрдэмтдийн бэлтгэсэн БНМАУ-ын түүхийн гурван боть, зохиогчтойгоор ба хамтын судалгаа болгон гаргасан монгол, зөвлөлтийн эрдэмтэд-түүхчдийн бүтээлүүд, түүнчлэн БНМАУ, ЗСБНХУ-ын гадаад бодлогын баримт материалуудын хэвлэсэн эмхэтгэлүүдэд монголын ардын төрийн гадаад бодлогын асуудал тусгалаа олжээ. Манай түүхийн ухааны доктор Ш. Сандаг «1921-1982 оны БНМАУ-ын гадаад бодлого» гэсэн ганц сэдэвт зохиол бичиж байна. Нөхөр Ш. Сандагийн энэ зохиол нь дээрхи хугацааны Монголын ардын төрийн гадаад бодлогыг олон улсын харилцааны хөгжилтэй уялдуулж тусгайлан судалж буй эрдэм шинжилгээний бүтээл юм.

Зөвлөлтийн эрдэмтэн Е.М.Жуков, М.И.Майский, С.Л.Тихвинский, Г.Ф.Ким, М.И.Сладковский, И.Я.Златкин, С.Д.Дылыков, М.С.Капица болон бусад олон хүмүүс, түүнчлэн ах дүү социалист бусад орны зарим эрдэмтний бүтээлүүдэд МАХН, БНМАУ-ын засгийн газраас олон улсын тавцан дээр баримталж буй чиг шугам нь Ардын эрхт Монгол улс ЗСБНХУ-д дараа нь нийт социалист хамтын нөхөрлөлд түшиглэн улс орноо капиталист биш замаар социализм өөд хөгжүүлэх аятай таатай гадаад нөхцлийг бүрэлдүүлсэн юм гэж тэмдэглэжээ. Мөн тэд энх тайвныг сахин бататгахын төлөө БНМАУ-ын явуулж буй тэмцлийг тусган харуулж, империалист, цэргийн эрхтнүүдээс манай улсын хувьд явуулж ирсэн эзлэн түрэмгийлэх бодлогыг илчлэн шүүмжилжээ.

Хөрөнгөтөн орнуудын монгол судлал БНМАУ-ын орчин үеийн байдлаар ерөнхий бүтээл бас нилээдийг гаргаж, тэдгээртээ манай улсын гадаад бодлогын аль нэг талыг авч үзсэн байна. Тэр ч байтугай АНУ-д БНМАУ-ын гадаад улс төрийн бодлогын байр суурийг тусгайлан судалж байдаг ажээ.

Капиталист орнуудын монгол судлалд бодит ба шинжлэх ухааны биш ийм хоёр чиглэл ажиглагдаж байна.

Бодит чиглэл нь Монгол дахь Ардын хувьсгалын бодит урьдчилсан, нөхцөл, монгол-зөвлөлтийн найрамдлын мөн чанар, БНМАУ-ын тусгаар тогтнолыг өмгөөлөн хамгаалахад ЗХУ-ын гүцэтгэсэн роль, шинэ нийгэм байгуулахад монголын ард түмний олсон амжилт зэрэг БНМАУ-ын түүх, орчин үеийн зарим чухал асуудлыг зөв ойлгон тусгаж байна. Ийм бүтээлийн тоонд АНУ-ын монголч эрдэмтэн О. Латтимор, Х. Гомбожав, японы монголч эрдэмтэн Ф. Исоно гэх зэрэг хүмүүсийн сүүлийн зарим бүтээлийг оруулж болно.

Шинжлэх ухааны биш чиглэлийн гол онцлог нь БНМАУ-ын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлыг үгүйсгэх, социалист бүтээн

байгуулалтанд түүний олсон түүхэн амжилтыг гуйвуулахад чиглэж байна. Зарим зохиогчид БНМАУ-ыг ЗХУ-д сэргүүлэн тавих зорилгоор манай орны олон улсын байдлыг тодорхойлохдоо «колони», «хамсаатан», «хязгаарлагдмал биеэ даасан байдлын онол» гэсэн үгнүүдийг өнөө болтол хэрэглэсээр байна. Тухайлбал АНУ-ын монгол судлаач Р. Рупен бичихдээ, БНМАУ «одоо биеэ даасан гэж нэрлэгдэж буй үндэстэнд байдаг эрх тэгш байдлын зарим нэг шинжтэй байна...»<sup>6</sup> гэсэн мөртөө өөрийнхөө «Хэн үнэн хэрэгтээ Монголыг захирч байна вэ?»<sup>7</sup> (Стэнфорд, Калифорни, 1979) гэдэг номонд БНМАУ, ЗХУ, тэдгээрийн гадаад бодлого, монгол-зөвлөлтийн (найрамдлыг элдэв муухайгаар дайрч гүтгээд, БНМАУ-ыг зөвлөлтийн цэргийн командлал «захирч»<sup>8</sup> байгаа мэтээр гүжирдэн бичжээ. Р. Рупен мэтийн хүмүүсээс манай орон, монгол- зөвлөлтийн найрамдалт харилцааг ийнхүү зориуд гуйвуулан гүтгэж байгаа «нотолгоо» нь үнэн бодит байдалд огтхон ч нийцэхгүй шинжлэх ухааны биш зүйл мөнөөр барахгүй монгол судлал дахь шинжлэх ухааны арга барилын эсрэг, коммунизмыг улангасан эсэргүүцдэг эл зохиогчдын өөрсдийн байр сууринаас хийсэн дүгнэлт даруй мөн.

Хөрөнгөтөн орнуудын монгол судлал дахь шинжлэх ухааны биш чиглэлтэй хятадын маоист түүхчид дуу хоолойгоо илэрхий нийлүүлж ирэв. Тэд манай орныг Хятадад хавсарган нийлүүлэх талаар Мао Зэдуны явуулж байсан бодлогыг «түүхийн үндэслэлтэй» болгохын тулд түүхийг бүдүүлгээр завхруулан гуйвуулах ажлыг хийж ирэв. Үүнийг БНХАУ-д цөөнгүй тоогоор хэвлэсэн ном, товхимол, өгүүллүүд тэрчилж байна. Тэдгээрт монгол угсаатнууд «эрт дээр үеэс хятадын хойт хэсэгт оршин амьдарсаар ирсэн»<sup>9</sup> гэх буюу Чингис хаан, түүнийг залгамжлагчид нь «Хятадын олон үндэстний төрийн эв нэгдлийг хангахад үлэмжийн их дэвшилт үүрэг гүйцэтгэсэн»<sup>10</sup> мэтээр хятадын түүхчид бичих болжээ.

Хятадын маоист түүхчдийн иймэрхүү «нотолгоо» бол бас л түүхийн үнэн бодит байдалд тохирохгүй, шинжлэх ухааны шаардлагыг хангахгүй байгаагаар үл барам манай орны төрийн бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолд өнгөлзөж буй оролдлого гэхээс өөрөөр үзэж болохгүй юм.

Иймэрхүү зүйл бол БНМАУ, БНХАУ-ын харилцааг социализм, энх тайвны эрх ашгийн үүднээс хэвийн болгох хүчий чармайлтад тус нэмэр болохгүй нь мэдээж хэрэг билээ.

Энэ бүхнээс үзэхэд, БНМАУ-ын гадаад бодлогыг манай түүхчид, олон улсын монголч эрдэмтэн-түүхчдээс шинжлэх ухааны арга барилаар тусгайлан судлах ажлыг улам эрчимжүүлэх явдал зүй ёсоор шаардагдаж байна.

## **К ВОПРОСУ ИЗУЧЕНИЯ ВНЕШНЕЙ ПОЛИТИКИ МНР**

### **(Резюме)**

Подробно остановившись на основных моментах развития отношений дружбы и сотрудничества МНР со странами мирового социализма, автор отмечает, что исторические условия развития МНР и СССР привели к взаимной дружбе и прочному союзу, направленному на решение задач

<sup>6</sup>R, Rupen. Mongols of the Twentieth Century, the Hague, p. 360 1964,

<sup>7</sup>R, Rupen. How Mongolia is really ruled, Stanford, 1979. California.

8. Мөн тэнд, 129-р тал.

9. «Монгол угсаатны товч түүх» (хятад хэл дээр) Хөх хот, 1977. 1-р тал.

10. «Гуанминь жибао», 1979 оны 9-р сарьу 116

Строительства нового общества и выполнение своего интернационального долга перед другими народами.

Монголо-советская дружба всегда служила и нынче служит основной гарантией свободы и независимости МНР, её успехов и процветания.

Выделяя вступление МНР в СЭВ в 1962 году, автор подчеркивает, что многостороннее сотрудничество в рамках СЭВ, дает монгольскому народу возможность использовать преимущества международного социалистического разделения труда, что способствует ускоренному развитию МНР.

Другим важным направлением внешней политики МНР является поддержка национально-освободительной борьбы народов Азии, Африки и Латинской Америки, развитие отношений дружбы и солидарности со странами социалистической ориентации, а также дружественных отношений с суверенными национальными государствами в интересах мира и социального прогресса.

Одним из основополагающих принципов внешней политики МНР было и остается последовательное осуществление ленинского принципа мирного сосуществования государств с различным общественным строем. Автор отмечает, что со времени вступления МНР в ООН в октябре 1961 года началась полоса признания МНР государствами иной социальной системы.

МНР вместе с Советским Союзом и другими миролюбивыми государствами ведет активную борьбу за предотвращение угрозы мировой термоядерной войны, за сокращение и запрещение ядерного и других видов оружия массового уничтожения, за прекращение гонки вооружений, за конструктивное решение назревших международных проблем путем политических переговоров, против опасных происков агрессивных империалистических кругов.

Выдвинутое в прошлом году ХУШ съездом МНРП предложение о разработке и заключении Конвенции о ненападении о неприменении силы в отношениях между странами Азии и района Тихого Океана» находит все большую поддержку как со стороны миролюбивых государств мира, так и со стороны широкой международной общественности.

Далее автор анализирует два основных этапа внешней политики МНР и их особенности. **На первом этапе**, охватывающем период с 1921 года по 1945 год народная Монголия, находясь вместе с Советским Союзом в капиталистическом окружении, проводила политику, направленную на упрочение государственной независимости, обеспечение экономической самостоятельности и создание мирных условий для некапиталистического развития, а в годы второй мировой войны оказание помощи советскому народу в жесточайшей схватке с германским фашизмом, непосредственное участие на стороне Объединенных Наций в разгроме японского милитаризма и установление мира на Дальнем Востоке. На втором этапе, начавшемся с 1945 г. и продолжающемся по сей день, МНР, значительно укрепив свое положение на мировой арене, вместе со странами социалистического содружества, проводит политику широкого международного сотрудничества и обеспечения мирных условий для строительства социализма, за мир и безопасность народов.

В последней части статьи автор останавливается на необходимости дальнейшего изучения вопросов внешней политики МНР как в монгольской исторической науке, так и в зарубежном монголоведении.